



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/71

Мандалговь

Г Эрх шилжүүлэн ажил Т
гүйцэтгүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр аймгийн ИТХ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 25 - ны өдрийн 15 дугаар тогтоолын 07 дугаар хавсралтын 2.1-д батлагдсан “Аймгийн төвийн хогийн менежмент” хэрэгжүүлэх ажлын эрхийг Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлсүгэй.

Хоёр. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, холбогдох материалыг 2017 оны 07 сарын 01-ний дотор Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/-д үүрэг болгосугай.

Гурав. Худалдан авах ажиллагааны бичиг баримтын бүрдлийг хянаж, журмын дагуу санхүүжилт олгохыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Санхүү төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

О.ЧУЛУУНБАТ

0200186